

Хичээлийн цаг

Сургуулийн хичээлийн цагийн хуваарилалт гаргахад туслаарай.

Оролт:

Эхний мөрөнд тухайн өдрийн хичээл эхлэх цаг /t_start/ болох 2 натурал тоо нэг мөрөнд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

2-р мөрөнд 1 цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа /t_continue/ болох 2 натурал тоо зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

3-р мөрөнд завсарлагааны үргэлжлэх хугацаа /t_break / болох 2 натурал тоо зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

4-р мөрөнд их завсарлагааны үргэлжлэх хугацаа /t_lunch/ болох 2 натурал тоо зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

5-р мөрөнд тухайн өдөр хэдэн цагийн хичээл орохыг илэрхийлэх 1 / N / натурал тоо өгөгдөнө.

6-р мөрөнд хэддүгээр цагийн дараа их завсарлагаатай болохыг илэрхийлэх 1 / M / натурал тоо өгөгдөнө.

Энд цаг болон үргэлжлэх хугацаа нь (цаг, минут) гэсэн эрэмбэтэй 2 натурал тоогоор илэрхийлэгдэнэ.

Гарлт:

1-р мөрөнд 1-р цагийн хичээлийн эхлэх дуусах цаг болох 4 натурал тоо, гэх мэтээр N-р мөрөнд N-р цагийн хичээлийн эхлэх дуусах цаг болох 4 натурал тоо тус тус зайгаар тусгаарлагдан хэвлэгдэнэ.

Жишээ оролт:

8 40

1 30

0 10

0 30

6

3

Жишээ гарлт:

8 40 10 10

10 20 11 50

12 0 13 30

14 0 15 30

15 40 17 10

17 20 18 50

Хязгаарлалт:

Хугацаа: 1 сек

$2 \leq N \leq 15$, $2 \leq M \leq 10$

Минут, цагийг илэрхийлэх утгын хязгаар:

t_start ба $t_continue$ нь цаг ба минутаар өгөгдөнө. $0 \leq \text{минут} < 60$, $0 \leq \text{цаг} < 24$

Харин t_break , t_lunch минутаар өгөгдөнө. Өөрөөр хэлбэл, цаг нь ямагт 0 байна.

$5 \leq t_break \leq 20$

$20 \leq t_lunch \leq 30$